



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/101/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Азхүү Утас: 99858616 Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ....	Error! Bookmark not defined.
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа.	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

МУЗГ

Монгол Улсын Засгийн газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
М.БАТБОЛД ТАНАА

2022.02.25 № 139
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Т. Байгалмаа* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,218,883.20	77,726,852.40
33	АВЛАГА	0.00	1,592,000.00
33500	Бусад авлага	0.00	1,592,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	1,592,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,726,883.20	33,694,852.40
35100	Түүхий эд материал	6,117,280.00	6,416,280.00
35110	Тусгай зориулалттай материал	6,117,280.00	6,149,280.00
35130	Эм боох материал	0.00	267,000.00
35400	Хангамжийн материал	23,609,603.20	27,278,572.40
35410	Бичиг хэргийн материал	1,185,080.80	3,142,050.00
35420	Аж ахуйн материал	21,339,152.40	22,526,652.40
35440	Түлш, шатах тослох материал	1,085,370.00	1,609,870.00
36	НӨӨЦИЙН БАРАА	14,492,000.00	42,440,000.00
36300	Тэжээлийн нөөц	14,492,000.00	42,440,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,467,281,894.24	1,990,569,266.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,467,281,894.24	1,990,569,266.75
39200	Биет хөрөнгө	1,438,233,144.34	1,977,883,016.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	388,356,262.76	456,456,262.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,663,386.44	-23,798,516.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,723,885.00	191,293,885.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-147,188,233.08	-102,045,104.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	98,444,799.10	93,187,997.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,024,232.44	-30,548,080.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,999,443.00	15,998,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,268,980.09	-5,247,395.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,137,447,635.00	1,682,263,255.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-250,149,390.47	-306,033,379.07
39216	Дуусаагүй барилга, байгууламж	64,555,342.00	6,355,342.00
39300	Биет бус хөрөнгө	13,298,749.90	12,686,249.86
39301	Програм хангамж	3,500,000.00	3,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,581,250.10	-3,193,750.14
39303	Бусад биет бус хөрөнгө	12,380,000.00	12,380,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,511,500,777.44	2,068,296,119.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,511,500,777.44	2,068,296,119.15
51	Засгийн газрын хувь оролцоо	1,511,500,777.44	2,068,296,119.15
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	353,817,116.23	353,817,116.23
51200	Хуримтлагдсан үр дүн	1,091,665,713.42	1,648,461,055.13
51210	Өмнөх үеийн үр дүн	951,253,464.24	1,091,665,713.42
51220	Тайлант үеийн үр дүн	140,412,249.18	556,795,341.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,017,947.79	66,017,947.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,511,500,777.44	2,068,296,119.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	750,184,332.00	1,061,419,565.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	312,898,925.00	619,717,655.70
120	Нийтлэг татварын бус орлого	312,898,925.00	619,717,655.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	312,898,925.00	13,596,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	355,000.00	13,596,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	312,543,925.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	605,906,155.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	215,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,285,407.00	441,701,910.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,237,407.00	11,468,210.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,237,407.00	11,318,210.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	428,048,000.00	430,233,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	428,048,000.00	430,233,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	558,097,082.82	504,624,223.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,097,082.82	504,624,223.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,538,009.82	444,453,823.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,520,500.00	246,595,533.00
210101	Үндсэн цалин	240,520,500.00	236,606,497.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	9,989,036.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,875,983.00	34,553,473.00
210201	Тэтгэврийн даатгал	20,314,991.00	24,675,389.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,389,996.00	2,488,971.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,912,997.00	1,991,176.31
210204	Ажилгүйдлийн даатгал	478,000.00	490,720.30
210205	Эрүүл мэндийн даатгал	4,779,999.00	4,907,215.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,623,536.00	9,911,027.00
210301	Гэрэл, цахилгаан	3,386,856.00	2,796,827.00
210302	Түлш, халаалт	7,186,680.00	7,028,000.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	86,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,837,282.00	20,201,640.80
210401	Бичиг хэрэг	5,056,310.00	3,610,830.80
210402	Тээвэр, шатахуун	13,230,272.00	12,001,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,884,700.00
210404	Ном, хэвлэл	264,000.00	295,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	831,590.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	454,200.00	578,000.00
210408	Бараа материал акалсны зардал	542,500.00	0.00
2105	Нормативт зардал	0.00	1,654,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,654,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,310,050.00	2,613,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,690,000.00	0.00
210604	Урсгал засвар	3,620,050.00	2,613,050.00
2107	Томилолт, зочны зардал	6,580,000.00	7,586,000.00
210702	Дотоод албан томилолт	6,580,000.00	7,586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,360,189.00	2,716,209.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,779,263.00	1,838,675.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	932,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,846.00	194,976.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	93,500.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	38,580.00	12,558.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,430,469.82	118,622,891.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,441,200.00	25,434,408.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,614,000.00	450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,375,269.82	92,738,483.19
212	ТАТААС	3,443,240.00	3,200,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,443,240.00	3,200,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,443,240.00	3,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,115,833.00	56,970,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,838,960.00	4,151,744.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,387,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,451,960.00	4,151,744.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,276,873.00	52,818,656.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,276,873.00	52,818,656.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	192,087,249.18	556,795,341.71
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,675,000.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,875,000.00	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	49,800,000.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	140,412,249.18	556,795,341.71

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	951,253,464.24	1,371,088,528.26
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	951,253,464.24	1,371,088,528.26
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	140,412,249.18	140,412,249.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,091,665,713.42	1,511,500,777.44
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,091,665,713.42	1,511,500,777.44
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,091,665,713.42	1,511,500,777.44
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	556,795,341.71	556,795,341.71
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,648,461,055.13	2,068,296,119.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	437,640,407.00	455,298,410.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	355,000.00	13,596,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	355,000.00	13,596,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	355,000.00	13,596,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	355,000.00	13,596,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,285,407.00	441,701,910.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,237,407.00	11,468,210.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,237,407.00	11,318,210.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	428,048,000.00	430,233,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	428,048,000.00	430,233,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	432,990,407.00	445,178,710.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,990,407.00	445,178,710.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,926,534.00	384,877,610.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,520,500.00	248,917,951.00
210101	Үндсэн цалин	240,520,500.00	238,928,915.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	9,989,036.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,875,983.00	32,209,055.00
210201	Тэтгэврийн даатгал	20,314,991.00	22,330,971.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,389,996.00	2,488,971.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,912,997.00	1,991,176.31
210204	Ажилгүйдлийн даатгал	478,000.00	490,720.30
210205	Эрүүл мэндийн даатгал	4,779,999.00	4,907,215.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,411,036.00	9,418,527.00
210301	Гэрэл, цахилгаан	3,386,856.00	2,796,827.00
210302	Түлш, халаалт	4,974,180.00	6,535,500.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	86,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,353,376.00	23,604,255.00
210401	Бичиг хэрэг	4,783,450.00	5,297,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,045,346.00	12,355,175.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	3,054,700.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	295,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	424,580.00	1,851,880.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	750,000.00
2105	Нормативт зардал	654,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	654,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,499,250.00	2,376,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,650,000.00	130,300.00
210604	Урсгал засвар	1,849,250.00	2,245,950.00
2107	Томилолт, зочны зардал	6,580,000.00	7,586,000.00
210702	Дотоод албан томилолт	6,580,000.00	7,586,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,360,189.00	3,110,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,779,263.00	2,232,530.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	932,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,846.00	194,976.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	93,500.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	300,000.00
210807	Газрын төлбөр	38,580.00	12,558.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,672,200.00	56,655,508.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,058,200.00	56,205,508.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,614,000.00	450,000.00
212	ТАТААС	3,400,000.00	3,500,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,400,000.00	3,500,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,400,000.00	3,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,663,873.00	56,801,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,387,000.00	3,982,444.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,387,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,982,444.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		52,818,656.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		52,818,656.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,650,000.00	10,119,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,650,000.00	10,119,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,650,000.00	10,119,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,650,000.00	10,119,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,650,000.00	10,119,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,650,000.00	-10,119,700.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэлийн	зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	445,025,700.00	391,011,544.00	54,014,156.00	87.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,275,700.00	387,261,544.00	54,014,156.00	87.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,775,700.00	379,779,100.00	53,996,600.00	87.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,049,500.00	248,917,951.00	2,131,549.00	99.15
210101	Үндсэн цалин	240,969,500.00	238,928,915.00	2,040,585.00	99.15
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	9,989,036.00	90,964.00	99.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,891,700.00	32,209,055.00	1,682,645.00	95.04
210201	Тэтгэврийн даатгал	23,849,700.00	22,330,971.40	1,518,728.60	93.63
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,500.00	2,488,971.87	21,528.13	99.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,008,400.00	1,991,176.31	17,223.69	99.14
210204	Ажилгүйдлийн даатгал	502,100.00	490,720.30	11,379.70	97.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,021,000.00	4,907,215.12	113,784.88	97.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,000,000.00	9,418,527.00	4,581,473.00	67.28
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	2,796,827.00	1,203,173.00	69.92
210302	Түлш, халаалт	9,800,000.00	6,535,500.00	3,264,500.00	66.69
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	86,200.00	113,800.00	43.10
2104	Хангамж, бараа материалын зардал	24,857,100.00	23,268,575.00	1,588,525.00	93.61
210401	Бичиг хэрэг	5,297,100.00	5,297,100.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,700,000.00	12,169,495.00	530,505.00	95.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,460,000.00	3,054,700.00	405,300.00	88.29
210404	Ном, хэвлэл	300,000.00	295,400.00	4,600.00	98.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	1,851,880.00	648,120.00	74.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,900,000.00	8,745,950.00	9,154,050.00	48.86
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.00
210602	Тавилга	8,000,000.00	0.00	8,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	3,400,000.00	2,245,950.00	1,154,050.00	66.06
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	7,586,000.00	2,414,000.00	75.86
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	7,586,000.00	2,414,000.00	75.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,260,000.00	1,477,534.00	4,782,466.00	23.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,600,000.00	600,000.00	4,000,000.00	13.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	250,000.00	750,000.00	25.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	194,976.00	5,024.00	97.49

Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	40,000.00	12,558.00	27,442.00	31.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,817,400.00	47,155,508.00	27,661,892.00	63.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,367,400.00	46,705,508.00	27,661,892.00	62.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	450,000.00	0.00	100.00
212	ТАТААС	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000,000.00	3,982,444.00	17,556.00	99.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	3,982,444.00	17,556.00	99.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,982,444.00	17,556.00	99.56
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,750,000.00	3,750,000.00	0.00	100.00
220001	Барилга байгууламж	3,750,000.00	3,750,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	445,025,700.00	393,808,044.00	51,217,656.00	88.49
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	371,936,100.00	380,211,544.00	-8,275,444.00	102.22
320001	Орон нутгийн төсвөөс	371,936,100.00	380,211,544.00	-8,275,444.00	102.22
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	73,089,600.00	13,596,500.00	59,493,100.00	18.60
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,792,000.00	13,596,500.00	1,195,500.00	91.92
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	58,297,600.00	0.00	58,297,600.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	8	8	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөг /
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,468,210.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	11,468,210.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,468,210.00
4	Хангамж, бараа материалын зардал	335,680.00
5	Тээвэр, шатахуун	185,680.00
6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,632,530.00
8	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,632,530.00
9	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.00
10	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.00
11	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,468,210.00
12	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,468,210.00
13	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	150,000.00
14	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,468,210.00
15	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	
16	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээллийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангай сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хангай сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах”, 67.1.2-д “Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах”, 67.1.3-д “Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Өөрийн боловсон хүчин, нутгийн иргэдийн оюуны болон материаллаг хүчин зүйлсийн бүхий л давуу тал нөөц бололцоонд тулгуурлан хүний хөгжлийг эрхэмлэх, байгаль орчныхоо онцлогт зохицсон өөрийгөө тэтгэдэг оновчтой бүтэц бүхий эдийн засагтай, хүн амын ажиллаж, амьдрах таатай орчинтой загвар сум болох” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангай сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 445.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 556.7 сая төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0	1.5	1.5	
Бараа материал	29.7	33.7	4.0	13.47
Нөөцийн бараа	14.5	42.4	27.9	192.41
Үндсэн хөрөнгө	1,467.3	1,990.6	523.3	35.66
Нийт хөрөнгө	1,511.5	2,068.2	556.7	36.83
Өр төлбөр	0	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,511.5	2,068.2	556.7	36.83

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,511.5	2,068.2	556.7	36.83
--	---------	---------	-------	-------

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын данс тайлант оны эцэст 1.5 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах авлагын үлдэгдэлтэй байна.
- Бараа материалын үлдэгдэл 13.4 хувиар өссөн байна.

Бараа материал, нөөцийн данс нь 29.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 44.1 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 0.2 сая төгрөг нийт 44.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 40.3 сая төгрөгийн зарцуулалт гарч, 33.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь бичиг хэрэг, аж ахуйн материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 35.6 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,467.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10.1 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 653.9 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 25.8 сая төгрөг, нийт 689.9 сая төгрөгөөр нэмэгдэж, шилжүүлсэн үндсэн хөрөнгө 73.9 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 92.7 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,990.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 556.7 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	530.9	430.2	-100.7
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/улсын төсөв/		-	
Нэмэлт санхүүжилтийн орлого	4.1	11.4	7.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	605.9	
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	0.2	
урьд оны үлдэгдлээс санхүүжих	52.0	13.7	-38.3
Үйл ажиллагааны орлого	587.0	1061.4	474.4
Цалин, шимтгэлийн зардал	129.5	281	151.5
Бусад бараа үйлчилгээний зардал	165.4	166.7	1.3
Урсгал шилжүүлэг	44.2	56.9	12.7
Үйл ажиллагааны зардал	339.1	504.6	165.5
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	-1.8		1.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	243.0	556.7	313.7

Хангай сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 474.4 сая төгрөгөөр өссөн нь зам, худаг, хог түр байршуулах цэг зэрэг үндсэн хөрөнгийг орлогод авсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 401.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 44.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 445.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 445.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 391.0 сая төгрөгийг зарцуулж, 52.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 11.4 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар цэрэг татлагын хоол, хүнс, өвс тэжээлийн зардалд зарцуулсан байна.

- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 0.8 сая төгрөг, аймгийн ИТХ-аас сургалтын зардалд зориулж 0.3 сая төгрөг, ГБХЗХГ-аас хамтарсан багийн шатахууны санхүүжилт 0.2 сая төгрөг, нийт 1.3 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу 2 иргэнээс 0.1 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын захирамжийн дагуу шатахууны зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд сумын Засаг даргын нөөц сангаас 15.0 сая төгрөгийн 1.5 тн ногоон тэжээлийг бэлтгэсэн байна. Мөн иргэдийн өргөдөл хүсэлтийн дагуу 2.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 113 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.4 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 445.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 87.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд ажлын дүрэмт хувцас худалдан авах зардалд 1.0 сая төгрөг, сургалт семинар, хурал, зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулах зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн сумын ЗДТГ-т ковид-19 цар тахалтай холбоотой 2 иргэнээс 0.4 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: 2020 онд ашиглалтад орсон 39.1 сая төгрөгийн анхны өртөгтэй УАЗ469 маркийн ХАНТЕР автомашины шатахууны зардалд 2.5 сая төгрөг, 2018 онд ашиглалтад орсон 9.9 сая төгрөгийн анхны өртөгтэй Toyota маркийн Probox автомашины шатахууны зардалд 3.7 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 8.3 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хангай сумын ЗДТГ нь 2021 онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Хангай сумын ЗДТГ нь 1.0 сая төгрөгөөр ажлын дүрэмт хувцас худалдан авсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-т “... ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалт зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Албан шаардлага

- Тайлант онд хувь хүмүүстэй холбоотой өвс тэжээлийн 1.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-д “өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 0.6 сая төгрөгийг вэб сайт хөгжүүлэх, хоол, материалын зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хангай сумын ЗДТГ	1	2.1					1	2.1		
	дүн	1	2.1					1	2.1		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хангай сумын ЗДТГ	1	1.0					1	1.0		
	дүн	1	1.0					1	1.0		
	Нийт дүн	2	3.1					2	3.1		